



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/262

Ховд


Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын Эрэгтэйчүүдийн хөгжлийн нийгэмлэгээс аймгийн алслагдсан Үенч, Алтай, Булган сумдад Нийгмийн хөгжилд эрэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх чуулганы үйл ажиллагааг сурталчлах, эрэгтэйчүүдийн манлайллыг нэмэгдүүлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулахад 2,000,000 төгрөгийн дэмжлэгийг үзүүлсүгэй.

2. Зардалд шаардагдах 2,000,000 төгрөг (хоёр сая)-ийг 2022 оны аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний 4.1-д заасан "Эрүүл иргэн" дэд хөтөлбөрийн зардлаас тооцож олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Б.Даваадорж) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Дэлгэрсайхан)-д хариуцуулсугай.



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 1337